

МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Чанарын тайлан

Хэрэглээний үнийн индекс

Улаанбаатар хот

2014 он

АГУУЛГА

1. Нийтлэг үндэслэл.....	4
2. Ойлголт, тодорхойлолт	5
3. Бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарын үзүүлэлт.....	5
3.1. Үнэн бодит, найдвартай байдал	5
3.2. Цаг хугацаандаа байх, шуурхай байдал	7
3.3. Хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байдал	7
3.4. Нийтэд хүртээмжтэй, ил тод байдал	8
3.5. Нийцтэй, харьцуулах боломжтой байдал	8
4. Нууцлалыг хангасан байдал	9

Товчилсон үгийн жагсаалт

ДБ	Дэлхийн банк
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
НӨТ	Нэмэгдэл өртгийн татвар
НСГ	Нийслэлийн статистикийн газар
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
ОУВС	Олон улсын валютын сан
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ӨНЭЗС	Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа
ӨОЗС	Өрхийн орлого, зарлагын судалгаа
ҮСГ	Үндэсний статистикийн газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХҮИ	Хэрэглээний үнийн индекс

1. Нийтлэг үндэслэл

Үнийн статистикт хэрэглээний үнэ нь хэрэглээний сагсанд төлөөлөх чадвартайгаар сонгогдсон бараа, үйлчилгээний худалдан авах үеийн үнэ байна. Хэрэглээний үнийн статистик судалгаанд тухайн барааны худалдан авагчийн худалдаж авсан үнийг буюу НӨТ, бусад татварыг шингээсэн худалдан авагчийн үнийг (тухайн барааг гэртээ хүргүүлсэн унааны хөлс, өөр бусад нэмэгдэл үйлчилгээний хөлсийг оруулахгүй) судлах бөгөөд сагсан дахь бараа, үйлчилгээний тодорхойлолт, үнэд нөлөөлөх шинж чанар (дэлгүүрийн төрөл, тээвэрлэлт, барааны чанар, хямдрал зэргийг хэрхэн тусгах талаар)-ыг тодотгон багтаадаг.

Хэрэглээний үнэ нь үндэсний эдийн засаг дахь үнийн тогтвортой байдлыг илэрхийлж, инфляцийн суурь мэдээлэл болдог тул хүн амын цалин, тэтгэвэр, тэтгэмж, бусад орлогыг индексжүүлэх гол үзүүлэлт болох төдийгүй тус улсын ДНБ-ийг зэрэгцүүлэх үнээр илэрхийлэх дефлятор болдог онцлогтой.

Хүн амын тархалт, нас хүйсний бүтэц, өрхийн орлогын түвшин, бараа, үйлчилгээний чанар зэрэг хүчин зүйлсийн өөрчлөлтөөс өрхийн хэрэглээний бүтэц байнга өөрчлөгдөж байдаг тул хэрэглээний үнийн индексийн төлөөлөх чадварыг хадгалах, үнэн зөв байдлыг тогтмол хангаж байх үүднээс олон улсын байгууллагуудаас эрхлэн гаргасан “Хэрэглээний үнийн индекс” гарын авлагад зөвлөснөөр ҮСХ нь 1991 оноос хойш 4 удаа хэрэглээний сагс, жинг шинэчилсэн бөгөөд 2010 оны ӨНЭЗС-ы үр дүнгээр шинэчилсэн сагсыг 2012 оны 1 дүгээр сараас эхлэн мөрдөж ХҮИ тооцож байна.

Хэрэглээний үнийн судалгааг цуглуулах бүс нутгийн хамрах хүрээ нь Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэг, 21 аймаг, эдгээрээс аймгийнхаа хүн амын 70 хувийг эзэлдэг 18 аймгийн 112 сум байна.

Мэдээлэл цуглуулах хугацаа нь Улаанбаатар хотын хувьд сар бүрийн 22-ноос 30-ны хооронд, сум болон аймгийн хувьд сар бүрийн 15-20-ны хоорондох хугацаа байна.

Мэдээллийг аймаг, нийслэлээс тусгай программ хангамжийн дагуу сар бүрийн 21-нд ҮСХ-нд дамжуулж, тус хороо нь үнийн статистик мэдээллийг боловсруулах, бараа, үйлчилгээний хувийн болон бүлгийн индексийг улсын түвшинд тооцох, тархаах үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна.

Хэрэглээний сагсанд сонгогдсон бараа, үйлчилгээний үнэ, тарифыг үнэ хариуцсан судлаачид судалгаанд хамрагдсан дүүрэг болон аймгуудын дэлгүүр, зах, үйлчилгээний 250 гаруй цэгүүдээс 2800 гаруй үнэ, тарифыг өөрийн биеэр хүрч цуглуулж байна.

2. Ойлголт, тодорхойлолт

Хэрэглээний сагс - үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалт юм. Хэрэглээний сагсанд хүн амын үйлдвэрлэлийн бус зориулалтаар худалдаж авсан бараа, үйлчилгээг сонгох ба тэдгээр нь шинж чанар, төрөл, хэлбэрээрээ тодорхой бүлэг, дэд бүлгүүдэд хуваагдана. Жишээ нь: хонины мах гэсэн нэр төрөл нь хүнсний барааны бүлэгт, мах, махан бүтээгдэхүүний дэд бүлэгт орно.

Хэрэглээний бараа, үйлчилгээний жин - өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувийн жин юм.

ХҮИ-ийн тооцоонд Ласпейресийн үнийн индексийн дараах томъёог ашиглаж байна.

Энд: I_p^L - t тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс

t - тайлант үе, 0-суурь үе

$$I_p^L = \frac{\sum_{i=1}^n P_{it} * Q_{io}}{\sum_{i=1}^n P_{io} * Q_{io}}$$

P_{it} - i ' барааны тайлант үеийн үнэ,

P_{io} - i ' барааны суурь үеийн үнэ,

Q_{io} - i ' барааны суурь үеийн худалдан

авсан тоо, хэмжээ

\sum - нийлбэрийн тэмдэг

3. Бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарын үзүүлэлт

Чанарын олон талт ойлголттой холбоотойгоор **статистикийн бүтээгдэхүүний чанар нь** хэрэглэгчийн үнэлэмж, төрөл бүрийн түвшний хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлага болон тэргүүлэх ач холбогдолтой мэдээллүүдийн чанараар тодорхойлогдож байна. ХҮИ-ийн чанарын үзүүлэлтийг ҮСХ-ны чанарын бодлогын баримт бичигт тусгасан дараах шалгуур үзүүлэлтүүдээр тодорхойлов. Үүнд:

3.1. Үнэн бодит, найдвартай байдал

Хэрэглээний үнийн судалгаанд тухайн үеийн /моментын/ үнийг судлах зорилготой тул үнийн судалгааг нийслэл хотод сар бүрийн 22-28 -нд, сум болон аймгийн төвд 18-20-нд батлагдсан маягтын дагуу тогтмол явуулдаг. Үнэ цуглуулах ажлыг ҮСХ-ноос баталсан дараах заавар, гарын авлага, каталогийн

дагуу холбогдох аймаг, сум, дүүргийн 28 мэргэжилтэн /үнэ цуглуулагч/ гүйцэтгэдэг. Үүнд:

- “Хэрэглээний үнийн индекс тооцох” үзэл баримтлал, ҮСГ-ын даргын тушаал №1/17, 2006 он;
- “Хэрэглээний үнийн индекс тооцох” аргачлал, ҮСХ-ны даргын тушаал № 1/28, 2008 он;
- Шинэчилсэн хэрэглээний сагс, жин, ҮСХ-ны даргын тушаал №181, 2011 он;
- Хэрэглээний үнийн индекс тооцох гарын авлага, /ОУВС, ОУХБ, НҮБ, ДБ-ны хамтран боловсруулсан/, 2004 он;
- Үнэ цуглуулах гарын авлага, 2009 он;
- Хэрэглээний сагсны бараа, үйлчилгээний зурагт каталог, 2012 он

Хэрэглээний үнийн индекс нь таслалаас хойш нэг оронгийн буюу аравтын нарийвчлалтай тооцогддог.

2014 оны 1 дүгээр сарын хэрэглээний үнийн судалгааг графикт хугацаанд нь явууллаа. Үнэ цуглуулах ажлыг холбогдох аймаг, сум, дүүргийн мэргэжилтнүүд ҮСХ-ноос болон ОУ-ын байгууллагуудаас гаргасан үзэл баримтлал, аргачлал, зурагт каталоги болон зааврыг дагаж мөрдөн ажилласан.

ҮСХ-ны зүгээс судалгаагаар гарч буй мэдээллийн үнэн зөв, найдвартай байдлыг хангах үүднээс судалгааны мэдээлэл цуглуулахаас эхлээд хэрэглэгчид тархаах хүртэл бүхий л үе шатанд дараах байдлаар хяналт тавьж ажиллалаа. Үүнд:

- ҮСХ-ноос өгсөн заавар, удирдамж, зурагт каталогийн дагуу үнийг цуглуулсан байдал;
- Тогтоосон хугацааны үнийг цуглуулсан байдал;
- Шивэгдэж ирсэн анхан шатны мэдээллийн үнэн зөв, бодит байдал;
- Үр дүнгийн уялдаа холбоо болон бодит байдал зэрэг болно.

Аймгуудын хүнсний бараа, ундаа, усны бүлгээс махны үнийг, тээврийн бүлгээс шатахууны үнийг, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн бүтээгдэхүүний үнийг үнийн мэдээ хариуцсан мэргэжилтэн болон судалгаанд хамрагддаг зарим цэгээс утсаар лавлан тодруулж баталгаажуулсан байна.

Улаанбаатар хотод борлуулагдаж буй махны дундаж үнийг хүнсний захуудын махны борлуулалтын хувийн жинг тодорхойлсон судалгааны дүнд үндэслэн 2014 оны 1 дүгээр сараас эхлэн жигнэсэн дундаж аргаар тооцож байна.

Махны борлуулалтын хувийн жинг харгалзан тооцохтой холбогдуулан Үндэсний статистикийн хорооны даргын 2008 оны 01/28 тоот тушаалаар батлагдсан “Хэрэглээний үнийн индекс” тооцох аргачлалд зохих өөрчлөлтийг оруулсан. Үүнд:

- Улаанбаатар хотод борлуулагдаж буй махны дундаж үнийг мах худалдаалж буй хүнсний захуудын борлуулалтын хувийн жинг харгалзан үзэж, махны төрөл тус бүрээр тооцоолно.

- Махны жигнэсэн дундаж үнийг $\bar{p} = \frac{\sum P_i Q_i}{\sum Q_i} = \frac{P_1 \cdot Q_1 + P_2 \cdot Q_2 + \dots + P_n \cdot Q_n}{Q_1 + Q_2 + \dots + Q_n}$

$$\bar{p} = \frac{\sum P_i Q_i}{\sum Q_i} = \frac{P_1 \cdot Q_1 + P_2 \cdot Q_2 + \dots + P_n \cdot Q_n}{Q_1 + Q_2 + \dots + Q_n}$$

Энд:

\bar{p} – Жигнэсэн дундаж үнэ

P_i – Мах борлуулж буй захын махны үнэ

Q_i – Мах борлуулж буй захын хувийн жин

3.2. Цаг хугацаандаа байх, шуурхай байдал

Тайлант сарын хэрэглээний үнийн индексийг ҮСХ-ны даргын тушаалаар оны эхэнд батлагдсан графикт хугацаанд хэвлэлийн бага хуралд танилцуулж, улмаар сарын бюллетень, танилцуулгад хэвлэн хэрэглэгчдэд хуваарийн дагуу тогтсон хугацаанд тархааж байна.

2014 оны 1 дүгээр сарын танилцуулгад хэрэглээний үнийн индексийг аймаг, бүс, улсын түвшинд тооцон 12 бүлгийн нийт 9 хүснэгтийг хэрэглэгчдэд хүргэж, тархаасан байна. /Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал 2014/1/

Энэ хугацаанд хүнсний гол нэр төрлийн 27 барааны үнийг 7 хоногийн давтамжтайгаар сард 4 удаа аймаг болон Улаанбаатар хотын түвшинд индекс тооцон, дундаж үнэ болон товч танилцуулгыг бэлтгэн НСГ болон ҮСХ-ны вэб сайтад байршуулан, хэрэглэгчдэд хүргэлээ.

3.3. Хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байдал

Хэрэглэгчтэй харилцах менежментийг сайжруулах, эргэх холбоотой ажиллах, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээтэй мэдээллийг судлах, статистик мэдээллийн хэрэглээний түвшинг тодорхойлох үүднээс хэрэглэгчийн бүртгэлийг программчлан, программын туршилт явагдаж байна. Хэрэглэгчдээс гарсан санал, хүсэлтийн дагуу бүтээгдэхүүний хэлбэр, дизайныг өөрчлөх, нийтэд хүртээмжтэй байх тал дээр байнга анхаарч ажилладаг.

Хэрэглээний үнийн статистик мэдээллийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр тархаадаг ба түүнчлэн хэрэглэгчид албан бичгээр болон өөрийн биеэр хандах, хэвлэлийн бага хурал, олон нийтийн мэдээллийн хэрэгслэлийг ашиглан мэдээлэл авч байгаа болно.

Хэрэглээний үнийн УБ хотын болон Улсын индексийг 2014 оны 1 дүгээр сарын байдлаарх мэдээллийг хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн тэдгээрийн дараах бүлэгт буюу “үндсэн” хэрэглэгчдэд тархаасан болно.

- Олон улсын валютын сан;
- Дэлхийн банк;
- Монгол банк;
- Эдийн засгийн хөгжлийн яам;
- Нийслэлийн статистикийн газар;

- Хэвлэл мэдээллийн агентлагууд, телевизүүд;

2014 оны 1 дүгээр сарын хэрэглээний үнийн индексийг

Хэвлэмэл бүтээгдэхүүнд:

- I сарын Танилцуулга;
- Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс (хувийн хэрэглээний зориулалттай бараа, үйлчилгээний ангиллын 4 оронгийн түвшинд дэлгэрэнгүйгээр)

Электрон, он-лайн бүтээгдэхүүнд:

- Статистик мэдээллийн систем www.1212.mn-д 1 дүгээр сарын мэдээллийн шинэчлэсэн хувилбараар.
- Монстат болон Ezstat аппликейшины 1 дүгээр сарын мэдээлэл зэрэг болно.

Хүнсний гол нэр төрлийн барааны үнийн 7 хоногийн судалгаанд хамрагддаг махны дундаж үнийг хүнсний зах тус бүрээр Инфо графикаар хэрэглэгчдэд хүргэдэг онцлогтой болсон.

3.4. Нийтэд хүртээмжтэй, ил тод байдал

ҮСХ-ны хувьд бүх хэрэглэгчдийг статистикийн мэдээллээр адил тэгш хангах зарчим баримталдаг бөгөөд хуулийн хүрээнд бүх мэдээлэл хэрэглэгчид нээлттэй, ил тод байдаг. Нийтэд хүртээмжтэй, ил тод байдлыг хангахдаа мэдээллийн нууцлалыг чандлан хадгалдаг.

Хэрэглэгчид хэрэглээний үнийн мэдээллийг хүснэгтэн, текст, график дүрслэл хэлбэрээр тархахаас гадна статистик мэдээллийн үйлчилгээний нэдсэн систем МОНСИС – www.1212.mn сайтад байрлуулан нийтэд үнэ төлбөргүйгээр хүргэж байна.

Нөгөө талаас хэрэглэгчид хүртээмжтэй, орон зай цаг хугацаанаас хамаарахгүйгээр хүссэн мэдээллээ авах боломжийг бүрдүүлдэг www.1212.mn вэб сайтын үзүүлэлтүүдийг iPhone, iPad төхөөрөмж ашиглан үзэх боломжтой ezStat аппликейшн, iPhone, iPad төхөөрөмжүүдэд зориулсан статистикийн хэвлэмэл бүтээгдэхүүнийг унших боломжтой Monstat аппликейшн-ыг ашиглан тархааж байна. Түүнчлэн Android үйлдлийн системтэй гар утас, таблет хэрэглэдэг хэрэглэгч бүр Play store-оос Monstat аппликейшнийг татан авч www.1212.mn вэб сайтын үзүүлэлтүүдийг авч ашиглах боломжтой боллоо.

3.5. Нийцтэй, харьцуулах боломжтой байдал

Таван жилийн интервалтайгаар хэрэглээний үнийн статистикийн суурийг шинэчилдэг ба шинэ жингийн бүтэц, шинэ аргачлал зэргээс цаг хугацааны харьцуулагдахуйц байдал өөрчлөгддөг тул энэхүү агуулгын хүрээний томоохон өөрчлөлтийг 5 жил тутам тусгаж, ХҮИ-ийн цаг хугацааны хувьд харьцуулах боломжийг хангадаг онцлогтой.

2014 оны 1 дүгээр сарын хэрэглээний үнийн мэдээнд цаг хугацааны болон орон зайн хувьд харьцуулагдахуйц байдал хангагдаж, өмнөх сар, өмнөх оны мөн үе, оны эхнээс гэсэн 3 хэлбэрээр тооцож байна.

Улирлын нөлөөллийг арилгасан индексээс бусад бүх төрлийн олон улсад мөрдөгддөг индексүүдийг тооцон гаргаж байна.

4. Нууцлалыг хангасан байдал

Монгол Улсын “Статистикийн тухай” хуулийн 22-р зүйлд статистикийн мэдээллийг хууль бусаар ашиглах, мэдээллийн нууцыг задруулахыг хориглосон байдаг.

Мөн ҮСХ-ны журмын дагуу үнийн статистик мэдээ хариуцсан ажилтан нь мэдээлэл цуглуулахаас тархаах хүртэл бүхий л үе шатанд мэдээллийн нууцлалыг хангаж ажилладаг бөгөөд мэдээллийг дарагдуулах, буруу ашиглахаас сэргийлж, улмаар бусад албан байгууллагаас хэрэглэгчдэд ХҮИ-ийн талаар буруу ташаа мэдээлэл гарсан тохиолдолд албан ёсны тайлбар болон залруулга хийдэг болно.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР